



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 18 өдөр

Дугаар 1/302

Ховд


Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан Амарсанаагийн цэцэрлэгт хүрээлэнг өв соёл, язгуур урлаг, амралт зугаалгын бүс болгон хөгжүүлэх зорилгоор хуучин хөшөө дурсгалыг сэргээн засварлахад зориулан материалын зардал болох 2,928,000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.


2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 2,928,000 төгрөг (хоёр сая есөн зуун хорин найман мянга)-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 5/07 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.8-д тусгагдсан Байгаль орчин, аялал жуулчлал, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, дэд бүтцийн салбарын дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээнүүдээс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх) нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Т.Жаргалсайхан)-д даалгасугай.



Б.ДҮГЭРЖАВ

207



**ХУУЧИН ХӨШӨӨ ДУРСГАЛЫГ СЭРГЭЭН ЗАСВАРЛАХАД  
ШААРДЛАГАТАЙ МАТЕРИАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

Д/д	Материалын нэр	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэгж үнэ /төгрөг/	Нийт /төгрөг/
1	5 хошуу малын хөшөө дурсгал засварлах	6	ш	428 000	428 000
2	Будаг	16,6	л	150 000	2 500 000
Нийт					2 928 000

-оОо-